

✓

**ТӨМӨР ЗАМЫН СУУРЬ БҮТЦИЙН ТӨМӨР БЕТОН ДЭР
БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар ХАГ-19/29260/13

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон дор дурдсан талууд харилцан тохиролцож байгуулав.

Нэр "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Р.Батсүх

Нэр "Дорнод ган хийц" ХХК, "Улаанбаатар БҮК" ХК, "Мон цемент билдинг материалс" ХХК, "Монгол бетон дэр" ХХК, "Энэрэл холдинг" ХХК-уудын түншлэл (цаашид "Бэлтгэн нийлүүлэгч" гэх), түүнийг төлөөлж "Дорнод Ган хийц" ХХК-ийн Ерөнхий захирал М.Даваасүрэн

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Бэлтгэн нийлүүлэгч талд Тавантолгой-Зүүнбаян чиглэлд баригдах төмөр замын бүтээн байгуулалтад хэрэглэгдэх, зохих стандартын шаардлага хангасан төмөр замын төмөр бетон дэр үйлдвэрлэж Захиалагчид нийлүүлэх, Бэлтгэн нийлүүлэгч тал уг гэрээнд заасан төмөр бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл, тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд Түншлэлийн оролцогч тус бүртэй гэрээ байгуулан төмөр бетон дэр худалдаж авах үүрэг үүсгэхтэй холбоотой харилцааг зохицуулж, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2. Түншлэлийн оролцогч тус бүрийн бүтээгдэхүүн хэсэгчлэн нийлүүлэх хуваарь, тоо, хэмжээг тэдгээрийн хооронд 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдөр байгуулагдсан "Хамтран ажиллах гэрээ"-ний дагуу гаргасан Түншлэлийн гишүүдийн Хамтын ажиллагааны хорооны шийдвэрээр тогтоож, Хавсралт-4-д заасан ерөнхий хуваарийн дагуу Захиалагчтай худалдах, худалдан авах гэрээ байгуулан нийлүүлнэ.

1.3. Түншлэлийн оролцогч хасагдсан, эсхүл нөмөгдсөн нь өнөөхүү гороог дууогавар болгох, шинэчлэн байгуулах үндэслэл болохгүй.

1.4. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон гэрээний дараах хавсралтуудаас бүрдэнэ. Үүнд:
Хавсралт-1: Компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл;

Хавсралт-2: Бүтээгдэхүүнд тавигдах техникийн шаардлага болон бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэхэд тавигдах техникийн нөхцөл;

Хавсралт-3: Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ;

Хавсралт-4: Бэлтгэн нийлүүлэгчийн төмөр бетон дэрийг Захиалагчид нийлүүлэх ерөнхий хуваарь, тоо хэмжээ;

Хавсралт-5: Түншлэлийг төлөөлж гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр, Захиалагчийн өмнө хариуцлага хүлээх зохицуулалтыг агуулсан түншлэгч талуудын хооронд байгуулсан "Хамтран ажиллах гэрээ":

1.5 Гэрээ, түүний хавсралтууд болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

Хоёр. Баталгаа

2.1. Захиалагч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 121, 2013 оны 28 дугаар тогтоолоор тус тус Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод заасан I, II үе шатны төмөр замын суурь бүтцийг барих болон концессын эрхтэй болохыг;

2.1.2 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 135 дугаар тогтоолд заасан эх үүсвэрээс төвлөрүүлэх хөрөнгөөр энэхүү гэрээнд заасан санхүүжилтийг олгох;

2.2 Бэлтгэн нийлүүлэгч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.2.1 Гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай Тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг;

2.2.2 Бэлтгэн нийлүүлэгч нь ажлыг Хууль тогтоомж, стандарт болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, иж бүрдэл, тоо хэмжээ бүрэн бетон дэрийг үйлдвэрлэж бэлтгэн нийлүүлэхэд бэлэн болгоно гэдгийг;

2.2.3 Талууд энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр Хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас оор бусад зорилгоор ашиглахгүй байх.

Гурав. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

3.1 Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн Талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

3.2 Гэрээний зүйл, заалт, үг, өгүүлбэрийг гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

Дөрөв. Гэрээг байгуулсанд тооцох

4.1 Гэрээнд заасан хавсралтууд бүрдсэн тохиолдолд Талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж, баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Захиалагч, Бэлтгэн нийлүүлэгч тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хууль зүйн адил хүчинтэй байна.

Тав. Төмөр бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл

5.1. Бэлтгэн нийлүүлэгч нь энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш төмөр бетон дэрний үйлдвэр шинээр барих, одоо үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал, нөөцөд тулгуурлан төмөр бетон дэр үйлдвэрлэх бэлтгэл ажлыг хангаж эхэлнэ.

5.2 Бэлтгэн нийлүүлэгч нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тасралтгүй хэвийн явуулж, үйлдвэрлэл явуулах санхүүгийн нөөц, боломж бүртгэл, зардлын хуваарилалтыг оновчтой хийх, хөрөнгийн эргэлтийг найдвартай байлгаж ажиллана.

5.3 Бэлтгэн нийлүүлэгч нь шинээр барих төмөр бетон дэрний үйлдвэрийг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ашиглалтад оруулсан байна.

5.4 Бэлтгэн нийлүүлэгч нийт төмөр бетон дэрийг Захиалагчид хүлээлгэн өгч дуусгах эцсийн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх гэж тооцоолж, Хавсралт-3-т заасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, Хавсралт-5-д заасан ерөнхий хуваарийн дагуу нийлүүлнэ.

5.5 Түншлэлийн оролцогч тус бүр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулахад шаардагдах төмөр бетон дэрний 1 ширхэгийг нь нэгдсэн нэг үнэлгээтэйгээр нийлүүлэх бөгөөд захиалагчийн заасан газарт хүргэж өгнө.

5.6 Түншлэлд Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэгдэж, төмөр бетон дэр нийлүүлэх оролцогч нь Монгол Улсын үндэсний үйлдвэрлэгч байна.

5.7 Түншлэлийн аль нэг оролцогч Захиалагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу бүтээгдэхүүнийг хэсэгчлэн нийлүүлэх боломжгүй болсон, эсхүл гэрээний 11.5-д зааснаар худалдах, худалдан авах гэрээ байгуулагдаагүй тохиолдолд Захиалагч нь тэргүүн ээлжид гүйцэтгээгүй үүргийн хэмжээгээр гүйцэтгэвэл зохих үүргийг Түншлэлийн бусад оролцогчдод шилжүүлнэ. Энэ тохиолдолд Түншлэлийн оролцогчид "Хамтран ажиллах гэрээ"-нд заасны дагуу Хамтын ажиллагааны хороогоор асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах бөгөөд энэхүү гэрээний 5.4-д заасан хугацаа, Хавсралт-5-д заасан бүтээгдэхүүн нийлүүлэх ерөнхий хуваарьт өөрчлөлт орохгүй.

Зургаа. Бэлтгэн нийлүүлэх төмөр бетон дэрд тавигдах шаардлага, нийлүүлэх нөхцөл

6.1. Энэхүү гэрээний дагуу Бэлтгэн нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэх төмөр бетон дэрийг үйлдвэрлэх, нийлүүлэх явц нь энэхүү гэрээний Хавсралт-5-д заасан хуваарь, Хавсралт-3-д заасан шаардлагыг хангасан байна.

6.2 Захиалагчид нийлүүлэх бүтээгдэхүүн нь энэхүү гэрээний Хавсралт-3-т заасан техникийн даалгавар, стандарт, дүрэм, журамд нийцсэн, Монгол Улсад үйлдвэрлэгдсэн байна.

6.3 Үйлдвэрлэж, бэлтгэсэн төмөр бетон дэрийг худалдах, худалдан авах, бүтээгдэхүүнийг Захиалагчид хэсэгчлэн нийлүүлэх хугацаа, хуваарь, байршил, тээвэрлэлт болон энэхүү гэрээгээр зохицуулаагүй холбогдох бусад асуудлыг Түншлэлд оролцогч тус бүртэй байгуулах худалдах, худалдан авах гэрээгээр тусгайлан зохицуулна.

6.4 Бэлтгэн нийлүүлэгч нь зохих журмын дагуу итгэмжлэгдсэн лабораториор нийлүүлэх төмөр бетон дэрийг шинжлүүлж, магадлуулсан байна.

6.5 Бэлтгэн нийлүүлэх төмөр бетон дэрэнд эрх бүхий байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээ, иж бүрдлийн хуудас, итгэмжлэгдсэн лабораторийн гэрчилгээ дагалдана.

6.6 Бэлтгэн нийлүүлэгч нь энэхүү гэрээний хугацаанд гэрээгээр тохиролцсон ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгүүд болон Захиалагчид шаардлагатай мэдээллийг бүрэн гаргаж өгнө.

6.7 Бэлтгэн нийлүүлэгч нь энэхүү гэрээгээр тохиролцсон ажлын тодорхой хэсгийг Монгол улсын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр туслан гүйцэтгүүлж Монгол Улсад үйлдвэрлүүлж болох бөгөөд туслан гүйцэтгүүлэгчээр гүйцэтгүүлсэн ажлын үр дүнг захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

6.8 Бэлтгэн нийлүүлэгчийн нийлүүлсэн төмөр бетон дэрний баталгаат хугацаа нь Тавантолгой-Зүүн баян чиглэлийн төмөр замын суурь бүтцийг бүрэн барьж дуусган улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулснаас хойш 4 жил байна.

Долоо. Төмөр бетон дэр нийлүүлэх хугацаа



7.1. Бэлтгэн нийлүүлэгч нь Хавсралт-5-д заасан хуваарийн дагуу, гэрээний 5.4-д заасан хугацаанд бүтээгдэхүүнийг нийлүүлсэн байна.

7.2. Бэлтгэн нийлүүлэгчийн ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаа, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу бүтээгдэхүүнд гарсан доголдлыг арилгасан зэрэг нь бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг зөрчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

7.3. Бүтээгдэхүүнийг хугацаанд нь бүрэн нийлүүлээгүй, эсхүл хугацаа хожимдуулж нийлүүлсэн нь Бэлтгэн нийлүүлэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги ногдуулах үндэслэл болно.

Найм. Бүтээгдэхүүний чанарын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

8.1. Бэлтгэн нийлүүлэгч нь чанарын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, эсхүл Захиалагч, төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамж, шаардлагыг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засч, доголдлыг арилгах, үүнээс үүсэн Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

8.2 Бэлтгэн нийлүүлэгч нь бүтээгдэхүүний доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагч, гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

8.3 Бэлтгэн нийлүүлэгч нь гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш 4 жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

Ес. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

9.1. Талуудын албан ёсны хаяг:

9.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани
Улсын бүртгэлийн дугаар: 9012001025
Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/
Утас: 7000-6622, 7010-6655,
Имэйл: info@mtz.mn

9.1.2. Бэлтгэн нийлүүлэгч: "Дорнод Ган хийц" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 123720
Регистрийн дугаар: 6095186

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: СБҮ-18/47/1

Хаяг: ҮБ хот, СХА, 7-р хороо, "Ган хийц" ХК-ийн 407 тоот

Утас: 99114923

Имэйл:

9.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг зөвхөн албан бичгээр харилцан солилцож байна.

9.3. Захиалагч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан: Замбаа инженер
О.Цырем Холбоо барих утас: 70002009 и-мэйл хаяг: info@mtz.mn

9.4. Бэлтгэн нийлүүлэгч талыг төлөөлж мэдээлэл солих ажилтан: ,
Холбоо барих утас:, и-мэйл хаяг:

9.5. Мэдээллийг бичгээр харилцахдаа факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрийг ашиглана.

9.6. Хойшлуулшгүй тохиолдолд Талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

9.7. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг Бэлтгэн нийлүүлэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

Арав. Бүтээгдэхүүний үнэ хэлс, төлбөр тооцоо

10.1. Бэлтгэн нийлүүлэгч нь энэхүү гэрээнд заасан чанар, стандартын шаардлага хангасан төмөр бетоныг нийлүүлэх нэг бүрийн үнэ нь 84.7 /наян дөрвөн доллар далан цент/ ам.доллар буюу Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар 230,726.19 *хоёр зуун гурав мянган, зөвдөн зуун, хорьон зургаан, таван, арван есөн шонго* төгрөг байх бөгөөд гэрээ байгуулсан өдрийн Монгол банкны албан ханш болно.

10.2 Гэрээний 1.2-т зааснаар Түншлэлийн оролцогч нартай байгуулах Худалдах, худалдан авах гэрээгээр хэсэгчлэн нийлүүлэгдэх бүтээгдэхүүний төлбөрийн асуудлыг зохицуулахдаа төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх бөгөөд ийнхүү төгрөгт хөрвүүлэн тооцох албан ханшийг тухайн өдрийн Монгол банкны зарласан ханшаар тооцно.

10.3 Энэхүү гэрээний 10.1-д заасан үнэнд НӨАТ, холбогдох бүх төрлийн татвар, хураамж, үндсэн ажлын зардал, бүтээгдэхүүнийг захиалагчийн заасан газарт хүргэх тээврийн зардал зэрэг холбогдох бүх зардлууд багтсан болно.

Арваннэг. Захиалагчийн эрх, үүрэг

11.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Бэлтгэн нийлүүлэгчээс шаардах эрхтэй.

11.2. Ажлын явцын тайланг Бэлтгэн нийлүүлэгчээс авах эрхтэй.

11.3. Бүтээгдэхүүний эрхийн болон биет байдлын доголдлыг шалган дагалдах баримт бичгийн хамт хүлээн авах, бүтээгдэхүүн байршуулах талбай агуулахыг бэлэн болгосон байна.

11.4. Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүний чанарт нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

11.5. Гэрээний 5 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл болон 6 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэрд тавигдах шаардлага, нийлүүлэх нөхцөлүүдийн аль нэгийг хангаагүй тохиолдолд Түншлэлийн оролцогчтой төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээ байгуулахаас татгалзах эрхтэй.

11.6. Гэрээний хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Бэлтгэн нийлүүлэгч талд үзүүлэх үүрэгтэй.

11.7. Бэлтгэн нийлүүлэгчээс гэрээнд заасан нөхцөлийн дагуу чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг энэхүү гэрээгээр тогтоосоон тоо хэмжээгээр, тогтоосон хугацаанд үйлдвэрлэж нийлүүлэхийг шаардах эрхтэй.

11.8. Бүтээгдэхүүнд илэрсэн доголдлыг арилгуулах буюу доголдолгүй бараагаар солиулах, доголдлыг арилгахад гаргасан зардлаа төлүүлэх, эсхүл гэрээнээс татгалзах шаардлага гаргах эрхтэй.

11.9. Гэрээнд заасан чанар, стандартын шаардлагад нийцээгүй, тоо хэмжээ, иж бүрдэл, дагалдах баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

11.10. Хууль тогтоомж, холбогдох бусад актад заасан эрх, үүргийг хүлээнэ.

Арванхоёр. Бэлтгэн нийлүүлэгчийн эрх, үүрэг

12.1. Бэлтгэн нийлүүлэгч тал нь гэрээ хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн төмөр бетон дэрний үйлдвэр барих, үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх бэлтгэл ажлыг хангаж, Хавсралт-3-д заасан шаардлага хангасан бүтээгдэхүүнийг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор холбогдох стандартын шаардлагын дагуу биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй үйлдвэрлэн, дагалдах баримт бичгийн хамт нийлүүлэхэд бэлэн болгох үүрэгтэй.

12.2. Гэрээний 5 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл болон 6 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэрд тавигдах шаардлага, нийлүүлэх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Захиалагчаас төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг шаардах эрхтэй.

12.3. Бэлтгэн нийлүүлэгч нь нийлүүлж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг хариуцна.

12.4. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бэлтгэх үеийн аливаа доголдол, дутагдал нь хяналт шалгалтын үед илэрвэл Захиалагч талын тогтоосон хугацаанд арилгах эсхүл шинээр хийж өгнө.

12.5. Бүтээгдэхүүнд илэрсэн доголдлыг арилгахтай холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна.

12.6. Захиалагчийг гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

12.7. Гэрээний талуудын аль нэг талын санаачилгаар гэрээнээс татгалзсан бол учирсан хохирол зардлыг нэхэмжлэх эрхтэй.

12.8. Давагдашгүй хүчин зүйлтэй холбоотойгоор Хавсралт-3-т өөрчлөлт оруулахаар Захиалагч талд хүсэлт гаргах эрхтэй.

12.9. Гэрээний хугацаанд бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүхий л асуудлыг хариуцах үүрэгтэй.

12.10. Хууль тогтоомж, холбогдох бусад актад заасан эрх, үүргийг хүлээнэ.

Арвангурав. Нууцлал

13.1. Хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

Арвандөрөв. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

14.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

14.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналыг бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

14.3. Саналыг хүлээн авсан тал 5 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

14.4. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арвантав. Гэрээний зөрчил, үүсэх үр дагавар, хариуцлага

15.1. Дараах тохиолдолд гэрээний Талууд хугацаа хэтрүүлсэн гэж үзэж Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн дагуу шийдвэрлэнэ. Хэрэв гэрээний Талууд нэмэлт хугацаа



тогтоосон бол нэмэлтээр тогтоосон хугацаанаас өмнө үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхгүй байна.

15.2. Бэлтгэн нийлүүлэгч нь гэрээний 5.4-д заасан хугацаанд, Хавсралт-5-д заасан хуваарийн дагуу бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй, чанарын шаардлага хангаагүйгээс хугацаа алдсан тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 1 хувьтай тэнцэх алдангийг Захиалагчид төлнө.

15.3. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах тохиолдолд Талууд бичгээр мэдэгдэнэ.

15.4. Түншлэлийн бүх оролцогчид гэрээний 5 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл болон 6 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэрд тавигдах шаардлага, нийлүүлэх нөхцөлүүдийн аль нэгийг хангаж чадаагүй, цаашид төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээ байгуулах боломжгүй болсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалж, учирсан хохирлыг шаардах эрхтэй.

15.5. Бэлтгэн нийлүүлэгч нь техник, тоног төхөөрөмж, санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний 5.4-д заасан хугацаанд нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн нийлүүлэх боломжгүй болсон нь үйл баримтаар тогтоогдсон нөхцөлд гэрээний зөрчил гэж Иргэний хуулийн 225.1, 249-р зүйлийн дагуу нөгөө тал нь гэрээнээс татгалзан, өөрт учирсан учирсан хохирлыг мөн хуулийн 219-р зүйлийн дагуу нөхөн төлүүлнэ.

15.6. Бэлтгэн нийлүүлэгч гэрээний 5 дугаар бүлэгт заасан бетон дэр нийлүүлэх урьдчилсан нөхцөл болон 6 дугаар бүлэгт заасан төмөр бетон дэрд тавигдах шаардлага, нийлүүлэх нөхцөлүүдийг хангасан боловч Захиалагч тал төмөр бетон дэр худалдах, худалдан авах гэрээ байгуулах үүргээ биелүүлээгүй бол өөрт учирсан хохирлоо нэхэмжилнэ.

15.7. Гэрээг нэг талын санаачилгаар цуцалсан бол Захиалагч нь гэрээг цуцлах өдрийг хүртэл Бэлтгэн нийлүүлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийг төлж, өөрийн өмчлөлдөө шилжүүлэн авна.

15.8. Гэрээний аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол нөгөө талдаа урьдчилан мэдэгдэх бөгөөд зөрчил гаргасан тал нь зөрчлийг арилгах арга хэмжээ авна.

Арванзургаа. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

16.1. Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйл гэж талуудын гэм буруутай болон болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй, тэдгээрийн хүсэл зориг, хяналтаас гадуур бий болсон, урьдчилан харах боломжгүй буюу зохих арга хэмжээг авсан ч сэргийлэх боломжгүй байсан, үүний улмаас Талуудын үүргийн гүйцэтгэлд саад учруулсан нөхцөл байдлыг хэлнэ. Үүнд:

16.1.1 Дайн байлдаан, иргэдийн бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт, улс төрийн хориг, газар хөдлөлт, усны үер, гал түймэр, бусад байгалийн аюулт үзэгдэл, эдгээртэй адилтгах нөхцөл байдал;

16.1.2 Засгийн газрын 2019 оны 135 дугаар тогтоолд заасан төслийн санхүүжилттэй холбоотой шийдвэрүүд зохих ёсоор хэрэгжээгүйн улмаас Захиалагч Гэрээний үүргээ биелүүлэх, Түншлэлийн оролцогчидтой худалдах, худалдан авах гэрээ байгуулах боломжгүй болсон;

16.1.3 Захиалагчийн төсөл хэрэгжүүлэх эрхийг өөр этгээдэд шилжүүлсэн, эсхүл төслийн ажлыг зогсооход хүргэсэн бусад асуудлаар Монгол улсын эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр гарсан;

16.2. Гэрээний 16.1-д заасан нөхцөл байдал үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тал нь нөгөө талдаа учирсан хохирлыг хариуцан арилгах үүргээс чөлөөлөгдөнө.

16.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ биелүүлж чадахгүй болсон тал нь энэ тухай нөгөө талдаа бичгээр шуурхай мэдэгдэх бөгөөд талууд шалтгааныг арилгахын төлөө боломжтой бүх арга хэмжээг авсан ч үр дүнд хүрээгүй бол аль нэг талын санаачилгаар гэрээг цуцална.

Арвандолоо. Маргааныг шийдвэрлэх

17.1. Хэрэв талуудын хооронд энэхүү гэрээ, түүний хэрэгжилттэй холбоотой маргаан, санал зөрөлдөөн эсхүл үл ойлголцол (Цаашид "Маргаан") үүссэн тохиолдолд тухайн тал нь үүсээд буй маргааныг гэрээнд заасан журмын дагуу шийдвэрлэх тухай мэдэгдлийг нөгөө талдаа мэдэгдэнэ.

17.2. Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх:

17.2.1 Маргаан шийдвэрлэх мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэнэ. Энэ хугацаанд шийдвэрлэж чадахгүй бол маргааныг шийдвэрлэх эрх бүхий төлөөлөгчдийг талууд томилно.

17.2.2 Эрх бүхий этгээдийг томилсноос хойш ажлын 20 хоногт маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд гэрээний талууд болон хамтран ажиллах гэрээний оролцогч талтай эвлэрлийн хэлэлцээ хийнэ.

17.2.3 Маргаан шийдвэрлэх мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 30 хоногийн хугацаанд талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ийн
ийн

Гүйцэтгэх захирал

Р.БАТСҮХ



Бэлтгэн нийлүүлэгчийг
төлөөлж:

"ДОРНОД ГАН ХИЙЦ" ХХК-

Ерөнхий Захирал

М.ДАВААСҮРЭН

